

МУИС-ИЙН ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАХ ЖУРАМ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Журмын зорилт, хамрах хүрээ

1.1 МУИС-ийн технологи дамжуулах журмын зорилт нь МУИС-ийн хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд шинээр бүтээсэн, сайжруулан хөгжүүлсэн технологийг эзэмших эрх эдлэх, түүнийг зах зээлд нэвтрүүлэх, түүнээс орох ашгийг хуваарилахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 МУИС-ийн технологи дамжуулах журам /цаашид “Журам” гэх/ нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн Газрын шийдвэр, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, МУИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлого зэргийг дагаж мөрдөнө.

1.3 Энэ журам нь МУИС-ийн харьяа бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, лаборатор болон МУИС-ийн хэрэгжүүлэх бусад төсөл, хөтөлбөрүүдэд нэгэн адил үйлчилнэ. МУИС-ийн оролцоотой салбар дундын (interdisciplinary) хүрээлэн, төв, лабораторийн судлаачийг энэхүү журамд хамруулах зорилгоор гэрээт судалгааны ажил гүйцэтгэгч гэж тооцно.

1.4 Энэ журам нь оюуны өмчийн хэлбэрээр хамгаалагдах технологийг эзэмших, арилжаалах, түүнээс орох ашгийг хуваарилахтай холбогдсон бүх эрхийг тодорхойлохоос гадна технологийн биет бүтээгдэхүүнийг ашиглах, захиран зарцуулах талаарх МУИС-ийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцыг тодорхойлно.

2 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тодорхойлолт

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1 “Технологи” гэж шинэ бүтээл, ашигтай загвар, нээлт, компьютерийн програм, түүнчлэн төрөл бүрийн хэлбэрээр бичигдсэн мэдээлэл, бичмэл материалыг оруулан өргөн хүрээгээр ойлгоно. Мөн “технологи” гэсэн ойлголтод шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болж, эдийн засаг, нийгмийн үр ашиг авчрах шинэ болон шинэчлэн сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шийдлийг илэрхийлэх инновацийг хамруулна.

2.1.2 “Судлаач” гэж МУИС-ийн дүрэмд заасан багш, ажилтныг;

2.1.3 “Зочин судлаач” гэж МУИС-ийн хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт гадны байгууллагаас хамрагдан оролцож байгаа этгээдийг;

2.1.4 “Суралцагч” гэж Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 15.1-д заасан этгээдийг, мөн докторын дараах сургалтанд хамрагдаж байгаа этгээдийг;

2.1.5 “МУИС-ийн нэгж” гэж МУИС-ийн дүрэмд заасан бүрэлдэхүүн сургууль, тэнхим, лаборатори, профессорын баг, МУИС-ийн бүрэлдэхүүн болон харьяаллын нэгжийг;

2.1.6 “Патент” гэж Монгол Улсын Патентийн тухай хуулийн дагуу тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч эсвэл түүнээс эрхийг нь шилжүүлэн авсан этгээд, тодорхой хугацаанд түүнийг эзэмших онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, Төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

2.1.7 “Зохиогчийн эрх” гэж Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасан зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн эрх бөгөөд, шууд эсвэл машин, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар харилцаж, мэдэрч болдог бичмэл, аман, зурмал болон бусад биет хэлбэрээр бүтээсэн бүтээлүүдийн эрхийг;

2.1.8 “Бараа, үйлчилгээний тэмдэг (цаашид “Барааны тэмдэг” гэх)” гэж Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуульд заасан иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг буюу бүтээсэн үг, үсэг, тоо, нэр, тэмдэг, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр, эсвэл биет зүйлс, тэдгээрийн хослолыг;

2.1.9 “Газар зүйн заалт” гэж Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуульд заасан тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолтыг;

2.1.10 “Интеграл хэлхээний маск загвар” гэж (цаашид “маск загвар” гэх) гэж металл, тусгаарлагч, хагас дамжуулагчийн үеүдээс бүрдсэн хагас дамжуулагч чип (chip)-ийн 3 хэмжээст зураглал, тооцоолол бүхий цуврал загварыг;

2.1.11 “Судалгааны биет хөрөнгө” гэж биет бус (буюу оюуны) бүтээлээс ялгагдахуйц, бодитоор түгээх боломжтой судалгааны биет үр дүнг (Тухайлбал интеграл хэлхээний чип, биологийн амьд биет, инженерчлэлийн загвар /engineering prototype/ болон зураг гэх мэт бодитоор түгээгдэх боломжтой бүтээлүүд) ;

2.1.12 “Мэдэгдэхүйц хэмжээ” гэж энэ журмын 7 дугаар зүйлд заасан хэм хэмжээг;

2.1.13 “Өмч хөрөнгө” гэж МУИС-ийн дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, лабораторын нарийн багаж, тоног төхөөрөмж, материаллаг бааз, хүний нөөц зэргийг;

2.1.14 “Нууц” гэж Монгол Улсын Өрсөлдөөний тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад холбогдох хуулиудад тодорхойлсон нууцын зэрэгтэй мэдээлэл, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээлэл, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг;

2.1.15 “Технологи задлах” (technology disclosure) гэж олон нийтийн хүртээл болоогүй бөгөөд судалгаа шинжилгээний ажлын үр дүн, нууц байсан технологийн тухай мэдээллийг Технологи дамжуулах төвд мэдэгдэн ил болгож, холбогдох хууль тогтоомжийн дагуу оюуны өмчийн хамгаалалт хийх ажиллагааг эхлэх үйл явцыг;

2.1.16 “Бүтээгч” гэж Патентын тухай хуулийн 3.1.6-д заасан этгээдийг;

2.1.17 “Зохиогч” гэж Зохиогч эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 3.1.1-д заасан этгээдийг;

2.1.18 “Бүрдэл” (Case) гэж технологи задлах нэг удаагийн үйл явцаас гарч ирэх патент, програм хангамж, эсвэл судалгааны биет хөрөнгө зэргийг;

2.1.19 “Роялти орлого” (Royalty Income) гэж оюуны өмчийг зах зээлд нэвтрүүлснээс гэрээний дагуу лицензийн төлбөр хэлбэрээр олох орлогыг;

2.1.20 “Шууд зардал” (out-of-pocket cost) гэж оюуны өмчийг патентаар бүртгүүлэх, хамгаалах, хүчинтэй байх хугацааг сунгах, мөн технологи дамжуулах, патентын маркетингийн зардал зэрэгт зарцуулах зарлагыг;

2.1.21 “Роялти ашиг” гэж роялти орлогоос шууд зардлыг хассаны дараа үлдэх ашгийг;

2.1.22 “Бүтээгчийн хувь” гэж зохион бүтээгч буюу зохиогчид энэ журмын дагуу хуваарилах роялти ашгийн хувь хэмжээг;

2.1.23 “Гарааны компани” гэж Монгол Улсын Инновацийн тухай хуулийн 3.1.8-д заасан аж ахуйн нэгжийг тус тус ойлгоно.

2.2 МУИС-ийн технологи дамжуулах журамд Монгол Улсын хууль тогтоомжид хэрэглэж хэвшсэн хэлбэрээр нь нэр томъёог ашиглах бодлого баримтлана.

3 дугаар зүйл. Оюуны өмч

3.1 Энэхүү журамд, цаашид технологийг эзэмших эрх эдлэх, эдийн засгийн эрх эдлэх, захиран зарцуулахтай холбогдсон үндсэн эрхийг "оюуны өмчийн эрх" гэнэ. Оюуны өмчийн эрх нь шинэ бүтээлд патент, шинэ бүтээгдэхүүний загварт гэрчилгээ; ашигтай загварт ашигтай загварын гэрчилгээ; барааны тэмдэгт гэрчилгээ; газар зүйн заалтад гэрчилгээ зэргийг Монгол Улсын холбогдох хуулийн дагуу олгосноос эхлэн үүснэ.

3.2 Интеграл хэлхээний маск загвар (integrated circuit mask work)-ын хувьд, Монгол Улсад бие даасан эрх зүйн акт байхгүй учир шинэ бүтээл, ашигтай загвар, зохиогчийн эрх зэргийн аль оновчтой хэлбэрээр хамгаална. (Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг "Технологи дамжуулах заавар"-аас харна уу.)

3.3 Технологийг дамжуулах болон арилжаалах үйл явц нь патент, зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийн эрхийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шилжүүлэх, эсвэл лицензээр ашиглуулах хэлбэрээр хэрэгжинэ.

3.4 Энэхүү журамд цаашид шинэ бүтээлийг голлон жишээ болгон авч үзэх бөгөөд тусгайлан заагаагүй бол ашигтай загварыг бас хамруулан ойлгоно.

3.5 Оюуны өмчийн эрхийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг МУИС-ийн Технологи дамжуулах төв /Technology Transfer Office, цаашид "ТДТ" гэх/-өөс авч болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ

4 дүгээр зүйл. Ерөнхий үзэл баримтлал

4.1 Оюуны өмч хэлбэрээр хамгаалагдах технологийг эзэмших, арилжаалах, түүнээс орох ашгийг хуваарилахтай холбогдсон бүх харилцааг энэ журмын 1.2 дахь заалтыг баримтлан зохицуулна.

4.2 МУИС-ийн нийгэмд үйлчлэх бас нэг чухал үүрэг нь технологи дамжуулалт бөгөөд сургалт судалгааны тэргүүлэх үндэсний их сургуулийн хувьд технологи дамжуулах үйл явц нь сургалт, судалгааны дараа эрэмбэлэгдэнэ.

5 дугаар зүйл. Патент ба зохиогчийн эрх

5.1 Энэ журмын 9 дүгээр зүйлд заасан суралцагчийн дипломын ажлаас бусад МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаач болон МУИС-ийн төсөл, хөтөлбөрүүдэд оролцож буй этгээдийн бий болгосон, хөгжүүлсэн шинэ бүтээл, ашигтай загвар, маск загвар, бүтээгдэхүүний загвар, судалгааны биет хөрөнгө болон компьютерийн програм хангамж зэрэг зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээлийн эрхийг дараах байдлаар эзэмшинэ. Үүнд:

5.1.1 МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг (facility) ашиглан бүтээсэн буюу хөгжүүлсэн патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, програм хангамж болон бусад зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээл, маск загвар, судалгааны биет хөрөнгө, барааны тэмдгийн эрхийг дараах нөхцөлүүдэд МУИС эзэмшинэ:

5.1.1.1 Иргэн, хуулийн этгээдтэй МУИС-ийн байгуулсан гэрээт судалгааны ажлын хүрээнд оюуны өмчийг бүтээсэн бол;

5.1.1.2 Энэ журмын 7 дугаар зүйлд тодорхойлсны дагуу МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг (facility) мэдэгдэхүйц хэмжээгээр (significant use) ашиглан оюуны өмчийг бүтээсэн бол;

5.1.1.3 Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар албан үүргийн дагуу (work for hire) бүтээсэн бол, эсвэл МУИС-тай бичгээр хийсэн гэрээндээ, тухайн бүтээлийн эдийн бус баялгийн эрхээс бусад зохиогчийн эрхээ МУИС-д шилжүүлэхийг зөвшөөрсөн бол.

5.1.2 Энэ журмын 5.1.1-д заасан ямар нэг хэлбэрээр технологийг МУИС эзэмших эрх үүсэхгүй нь тодорхой болсон нөхцөлд бүтээгч буюу зохиогч нь эзэмшин захиран зарцуулах эрхтэй.

5.1.3 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу бичмэл гэрээнд өөрөөр заагаагүй бол орон тооны бус буюу гэрээт ажилтны гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнг гүйцэтгэгч нь эзэмшинэ.

5.1.4 МУИС эзэмших эрхээ эзэмшихгүй болохоо илэрхийлсэн тохиолдолд бүтээгч буюу зохиогч нь бүтээлийг эзэмшин, захиран зарцуулах эрхтэй.

6 дугаар зүйл. Захиалгат судалгаа ба бусад гэрээт ажил

6.1 Засгийн Газрын захиалгат судалгааны ажлын явцад анх санаачлан гаргасан, эсвэл бодит нөхцөлд буулган бүтээсэн шинэ бүтээлийн тухайд МУИС-ийн эдлэх эрх нь Засгийн Газартай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно. Засгийн Газар онцгой эрхгүй лиценз (non-exclusive license) эзэмших бөгөөд МУИС-д түүнийг эзэмших эрх хадгалагдах ба лиценз олгох болон бусад аргаар шинэ бүтээлийг бодит хэрэглээнд нэвтрүүлэх үүргийг МУИС хүлээнэ.

6.2 Үйлдвэр, компанийн захиалгат судалгааны ажлын хүрээнд бүтээсэн оюуны өмчийн эзэмших эрхийг, гэрээнд нарийвчлан заагаагүй бол МУИС эдлэж болох бөгөөд тухайн захиалагч байгууллага давуу эрхтэйгээр лицензээр эзэмшиж болно.

6.3 Засгийн Газрын захиалгат судалгааны ажлын зохиогчийн эрх авах шалгуур хангасан бүтээлийг эзэмших онцгой эрхийг Засгийн Газартай байгуулсан гэрээний дагуу зохицуулна. Засгийн Газар зохиогчийн эрхийн шимтгэл (royalty-free)-гүй лиценз эзэмшиж болох бөгөөд энэ тохиолдолд зохиогчийн эрх нь МУИС-д үлдэнэ.

6.4 Бүтээлийг бусад байгууллагын захиалсан гэрээт судалгааны ажлын хүрээнд бүтээсэн бол зохиогч нь тухайн бүтээлийг хэвлүүлэх, эсвэл түүнтэй төстэй хэлбэрээр нийтэд дэлгэрүүлэхдээ захиалагч талтай байгуулсан гэрээнд энэ талаар мэдээлэх үүрэг хүлээсэн эсэхийг нягтлах үүрэгтэй.

6.5 МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаачид судалгааны ажлын гэрээний заалтуудыг хэрхэн ойлгох талаар мэдээлэл, туслалцаа авах бол, Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэст хандана.

6.6 Захиалгат судалгааны ажлын гэрээний заалт нь уг гэрээний дагуу судалгааны ажлыг гүйцэтгэсэн бүх этгээдэд МУИС-иас цалинжсан эсэхээс үл хамааран адил үйлчилнэ. Иймд судалгааны ажилд оролцох бүх этгээд МУИС-ийн эрхийг хүлээн зөвшөөрч, 5-р бүлэгт заасан “Шинэ бүтээл, Үнэт мэдээллийн нууцын тухай гэрээ”-нд гарын үсэг зурах үүрэгтэй

7 дугаар зүйл. МУИС-ийн өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээнд ашиглах

7.1 МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаач, МУИС-ийн хөтөлбөрт оролцож буй бусад этгээд МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашиглан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, компьютерийн програм хангамж, эсвэл зохиогчийн эрхийн шалгуур хангасан бусад бүтээл, маск

загвар, эсвэл судалгааны биет хөрөнгө бүтээсэн бол МУИС нь патент, зохиогчийн эрх, эсвэл бусад биет бүтээл, эсвэл оюуны өмчийн эрхийг эзэмшинэ.

7.2 Хэрвээ бүтээл нь гуравдагч этгээдээс захиалсан, эсвэл бусад гэрээт судалгааны ажилд хамаарахгүй бол МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласан эсэхийг бүтээгч буюу зохиогчийн харьяалагдах нэгжийн удирдлага хянаж саналаа тусгай маягт (А1 маягт)-ын дагуу илэрхийлж, ТДТ-д хүргүүлнэ

7.3 МУИС-ийн албан өрөө, номын сан, засварын цех, харилцаа холбооны хэрэгсэл болон өгөгдөл хадгалах сервер зэргийг ашигласан тохиолдолд МУИС-ийн өмч хөрөнгийг (facility) мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласанд тооцохгүй.

7.4 МУИС-иас тусгайлан санхүүжүүлээгүй судалгааны ажлыг хориглоогүй эх үүсвэрээс цалин авч гүйцэтгэсэн бол МУИС-ийн санхүүжилтийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласанд тооцохгүй.

7.5 МУИС-иас сурах бичиг, сургалттай холбоотой номыг зохиоход зориулан төсөв зарцуулаагүй тохиолдолд сургалтын материал болгон бичсэн сурах бичиг, номыг “мэдэгдэхүйц хэмжээний хэрэглээ” ангилалаас хасч тооцно

7.6 Шинэ бүтээл, компьютерийн програм хангамж, эсвэл зохиогчийн эрхийн шалгуур хангасан бусад бүтээл, маск загвар, эсвэл судалгааны биет хөрөнгийг доорх нөхцөлд бүтээсэн буюу хөгжүүлсэн бол МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг ашиглан бүтээсэнд тооцохгүй. Үүнд:

7.6.1 Зөвхөн маш бага хэмжээний санхүүжилт ашигласан бол;

7.6.2 Шинэ бүтээл, компьютерийн програм хангамж, эсвэл зохиогчийн эрхийн шалгуур хангасан бусад бүтээл, маск загвар, эсвэл судалгааны биет хөрөнгө нь тухайн судлаачийн МУИС дахь судалгааны үндсэн чиглэл, эсвэл захиалгат судалгааны ажлын сэдвийн хүрээнд хамаарахгүй бол;

7.6.3 Зөвхөн маш бага хугацаанд чухал ач холбогдолтой тоног төхөөрөмжийг ашигласныг харьяалагдах удирдлага нь тодорхойлсон бол, эсвэл зөвхөн ач холбогдол багатай өмч хөрөнгө, тоног төхөөрөмж хэрэглэсэн бол (жишээлбэл: албан тасалгаа, номын сан, энгийн хэрэглээний компьютер, засварын цех зэрэг нь ач холбогдол багатай нөөцөд тооцогдоно.);

7.6.4 Бүтээлийг бүтээгч буюу зохиогчийн хувийн, ажлын бус цагт бүтээсэн бол.

8 дугаар зүйл. Зохиогчийн хувийн бүтээл

8.1 Шинжлэх ухааны ном, сурах бичиг, өгүүлэл болон бусад шинжлэх ухааны хэвлэлүүд түүнчлэн олон нийтэд зориулсан утга зохиолын ном, яруу найраг, хөгжмийн зохиол ба бусад урлагийн бүтээл зэргийг дараах нөхцөлд МУИС зохиогчийн эрхийг эдлэхгүй. Үүнд:

8.1.1 Судлаач, суралцагч нь өөрөө бие даан хувиараа бүтээсэн бол;

8.1.2 МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгөнөөс энэ журмын 7 дугаар зүйлд зааснаар “мэдэгдэхүйц хэмжээнд” ашиглаагүй бол;

8.1.3 Аливаа захиалгат болон бусад гэрээт төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамаарахгүй бол.

8.2 МУИС-ийн судлаач албан үүрэгтээ хамааралгүй бүтээсэн оюуны өмчийн зохиогчийн эрхээ эзэмших хүсэлт гаргасан бол МУИС нь хүсэлтийг санхүүжүүлэгч тал ба харьяалагдах МУИС-ийн нэгжийн удирдлага зөвшөөрсний дагуу хүлээн авч эрхийг нь зохиогчид шилжүүлнэ. Энэ тохиолдолд зохиогч нь тусгай маягт (А1 маягт)-ыг бөглөн ТДТ-д өгсөн байна.

9 дүгээр зүйл. Суралцагчийн дипломын ажил

9.1 Суралцагчийн дипломын ажлын зохиогчийн эрхийг Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу дараах тохиолдолд МУИС эзэмшинэ. Үүнд:

9.1.1 МУИС-аас цалин, хөлс, тэтгэлэг, буцалтгүй тусламж (грант) хэлбэрээр санхүүжилт олгосон судалгааны ажлыг багтаасан бол;

9.1.2 МУИС-ийн эзэмшдэг багаж, тоног төхөөрөмж, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашиглаж хийсэн бөгөөд МУИС оюуны өмчийг нь эзэмшдэг судалгааны ажлыг бүхлээр нь, эсвэл хэсэгчлэн багтаасан бол.

9.2 Суралцагч нь дипломын ажлын зохиогчийн эрхийг эзэмшиж байгаа тохиолдолд зохиогчийн эрхийн шимтгэлгүй ашиглах, олшруулах, олон нийтэд түгээх эрхийг МУИС-д олгоно.

9.2.1 Зохиогчийн эрхийн хязгаарлалт тогтоогоогүй нөхцөлд МУИС-ийн тоног төхөөрөмж, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашиглан гүйцэтгэсэн дипломын ажлын зохиогчийн эрхийг суралцагч нь эзэмшихгүй боловч дээрх 9.1.2 дахь заалтын хувьд дипломын ажилд багтсан компьютерийн програмын код, патентлагдах боломжтой эд зүйлс, бусад оюуны өмчийн эрхийг энэ журмын 7 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

10 дугаар зүйл. Барааны тэмдэг

10.1 МУИС-д бүтээсэн бүтээгдэхүүн ба үйлчилгээнд хэрэглэх барааны ба үйлчилгээний тэмдэг нь МУИС-ийн өмч байна.

10.2 МУИС-ийн нэр, бэлэг тэмдэг, уриа үг зэргийг ашиглах харилцааг тусгай журмаар зохицуулна.

11 дүгээр зүйл. Компьютерийн програм хангамжийг хэрэглэх

11.1 МУИС-д хэрэглэгдэж байгаа компьютерийн програм хангамж ба мэдээллийн сангийн эрхийг хэрэглэгч, эсвэл гуравдагч этгээд эзэмшиж байгаа бол, эсвэл зохиогчийн эрх болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан бол, эсвэл лицензийн болон бусад гэрээгээр зохицуулагдсан бол МУИС-ийн хэрэглэгчид тухайн программ хангамж, мэдээллийн сангийн эрхийг эзэмшигчийн тогтоосон хязгаарлалтуудыг дагаж мөрдөнө.

11.2 Компьютерийн програм хангамж, мэдээллийн сангийн эрхийг эзэмшигч нь тогтоосон хязгаарлалтынхаа нөхцөлүүдийг МУИС-д мэдээлэх үүрэгтэй.

12 дугаар зүйл. МУИС-ийн бүтээгч буюу зохиогч нарт эрх шилжүүлэх

12.1 Бүтээгч буюу зохиогч нь бүтээлээ эзэмших эрх хүссэн нь үндэслэлтэй тохиолдолд МУИС бүтээлийн оюуны өмчлөлийн асуудалд оролцохгүй байж (stand aside) болно. Энэ тохиолдолд хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

12.1.1 Технологийг нийтэд дэлгэрүүлэх явцыг эрчимжүүлэх;

12.1.2 Гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ зөрчихгүй байх;

12.1.3 Аливаа сонирхолын зөрчилдөөнд оролцохгүй байх.

12.2 Өмчлөлийн асуудалд оролцохгүй тохиолдолд МУИС нь технологийн талаар гэрээнд заасан эрхээсээ татгалзаж, бүтээгч буюу зохиогч нарт оюуны өмчөө эзэмших

эрхийг нь нээж өгнө. Бүтээгч буюу зохиогч тусгай маягт (А1 маягт)-ыг бөглөн ТДТ-д хүргүүлэн өгч МУИС-ийг эрхээсээ татгалзахыг хүссэн хүсэлт гаргана.

12.3 Патентын шалгуур хангасан шинэ бүтээл нь **Засгийн Газраас санхүүжсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд** бий болсон тохиолдолд, МУИС нь эрхээсээ татгалзвал эзэмших эрх нь Засгийн Газарт үлдэх бөгөөд үүний дараа бүтээгч буюу зохиогч уг бүтээлийн эрхийг олгохыг хүссэн хүсэлтээ Засгийн Газарт гаргаж болно (энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Технологи дамжуулах заавар” аас үзнэ үү).

12.4 **Аж үйлдвэр санхүүжүүлснээр** лицензийг нь эзэмших эрхтэй болсон судалгааны ажлын үр дүнг бүтээгч буюу зохиогч нь эзэмшихийг хүсвэл захиалагч буюу санхүүжүүлэгч талын зөвшөөрлийг авсны дараа МУИС эрхийг шилжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ, ХАМГААЛАХ БА ДАМЖУУЛАХ

13 дугаар зүйл. Чиг үүрэг

13.1 МУИС-ийн технологийг нийгмийн тусын тулд дамжуулах чиг үүргийг Технологи дамжуулах төв (ТДТ) хэрэгжүүлнэ.

13.2 ТДТ энэ журмын 3-р бүлэгт заасны дагуу технологийг үнэлж, оюуны өмчийн хамгаалалт хийж, тухайн технологийг судалгааны зорилгоор дэлгэрүүлэхэд туслалцаа үзүүлэх ба зэх зээлд нэвтрүүлэх боломжтой технологийг сонгон авч, 4-р бүлэгт заасан лицензийн гэрээг байгуулах болон арилжих үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Технологи задлах

14.1 Технологи дамжуулах эхний алхам нь МУИС-ийн Технологи задлах маягтыг (А2 маягт) ТДТ-д илгээснээр эхэлнэ. Технологи задлах маягтын хамт “МУИС-ийн технологийн оюуны өмчлөлийг шилжүүлэн авах хүсэлт” (А1 маягт)-ийг хүлээн авснаас бусад тохиолдолд ТДТ нь тухайн технологид патент (эсвэл оюуны өмчийн бусад хэлбэрээр хамгаалах) авах болон зах зээлд нэвтрүүлэх боломжийг судлах үйл ажиллагааг эхлүүлнэ.

14.2 ТДТ нь Технологи задлах маягтыг хүлээн авмагц, хувийн дугаар олгож тухайн технологийг үнэлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.

15 дугаар зүйл. Патент, хамгаалал

15.1 Судалгааг санхүүжүүлэгч буюу захиалагч тал хүсэлт гаргаагүй тохиолдолд, эдийн засгийн тодорхой үр ашиг багатай оюуны бүтээлийг МУИС нь патент болгон хамгаалах ажлыг хийхгүй.

15.2 МУИС нь лицензийн гэрээгээр зах зээлд нэвтрүүлэх боломжтой эсвэл захиалгат судалгааны ажлын гэрээнд заасан тохиолдолд шинэ бүтээлийг патент болгон эрхийг нь хамгаална. Шинэ бүтээлийг патентын эрхээр хамгаалах үйл явцыг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙН АРИЛЖААНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ”-д зааснаар зохицуулна.

15.3 Патент хүссэн мэдүүлэг гаргахаас өмнө тухайн шинэ бүтээлийн талаар эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлэх, үзэсгэлэнд тавих зэргээр аман буюу бичгийн аливаа нэгэн хэлбэрээр олон нийтэд дэлгэх шаардлага гарсан тохиолдолд ТДТ-тэй

зөвшилцөнө (Энэ талаар “Технологи дамжуулах заавар”-аас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу).

15.4 Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх тохиолдолд, патентын эрхийн талаар ТДТ-тэй урьдчилан зөвшилцөж, ТДТ зохих шийдвэр гаргасны дараа хэвлүүлнэ.



16 дугаар зүйл. Зохиогчийн эрхийг нотлох ба бүртгэх

16.1 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээл, жишээлбэл ном, өгүүлэл, хэвлэл, програм хангамжийн код зэрэг бүтээлийн зохиогчийг тодорхойлж, бүрэн бүтэн байдлыг нь баталгаажуулна.

16.2 Бүтээлийг ашиглах онцгой эрх эзэмшигч нь МУИС байх тохиолдолд, эрхээ нийтэд таниулах зорилгоор зохиогчийн эрх хамгаалагдсаныг илэрхийлэх дараах таних тэмдэгийг байрлуулна.

"Зохиогчийн эрхтэй © [Он] МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ. Бүх эрх хуулиар хамгаалагдсан."

"Copyright © [Year] NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA. All rights reserved."

16.3 Таних тэмдэг дэх он нь бүтээлийн анх нийтлэгдсэн он байна. Дээрхээс өөр таних тэмдгийг МУИС-ийн эзэмшлийн бүтээлд хэрэглэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Барааны тэмдгийг нотлох ба бүртгэх

17.1 Барааны тэмдгийг МУИС-ийн тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээ, компьютерийн програм хангамж зэрэг технологийн дэвшилтэт бүтээгдэхүүнтэй холбогдох нэр, бэлгэ тэмдгийг бусдаас ялган хамгаалахад хэрэглэнэ.

17.2 Оюуны өмчийн газарт бүртгүүлэхээс өмнө барааны тэмдгийн ард ТМ, үйлчилгээний тэмдгийн ард SM тэмдгийг тус тус байрлуулж болно. Барааны тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгүүлсний дараа "®" тэмдгийг хэрэглэнэ.

17.3 МУИС-ийн эзэмшдэг барааны тэмдгийг бүртгүүлэх, хэрэглэх, захиран зарцуулахтай холбоотой асуудлыг ТДТ хариуцна..

18 дугаар зүйл. Маск загварыг нотлох ба бүртгэх

18.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тусгагдаагүй тул, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн дагуу бүртгүүлж, хамгаалуулна. ("Технологи дамжуулах заавар"-аас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу)

18.2 Маск загварыг эзэмших, ашиглах эрхээ нийтэд таниулах зорилгоор МУИС-ийн эзэмшлийн маск загварыг ашиглан бүтээсэн бүх хагас дамжуулагч чип дээр дараах таних тэмдгийг байрлуулна.

"Маск загвар (М) МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ эсвэл МУИС"

"Mask work (M) NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA or NUM"

19 дүгээр зүйл. Судалгааны биет хөрөнгө (СБХ)

19.1 Судалгааны биет хөрөнгийг (СБХ), тухайлбал биологийн материал, компьютерийн програм хангамж зэргийг патент эсвэл зохиогчийн эрхийн аль тохиромжтой байдлаар хамгаалж, лицензийн гэрээгээр эсвэл бүхэлд нь арилжаалах хэлбэрээр зах зээлд нэвтрүүлнэ. СБХ-ийг лицензийн гэрээгээр дамжуулахдаа 4-р бүлэгт заасныг баримтална. ("Технологи дамжуулах заавар" аас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу)

19.2 Арилжааны эсвэл арилжааны бус лицензтэй СБХ-ийг зөвхөн судалгааны зорилгоор, санамж бичиг буюу албан ёсны лицензийн гэрээний дагуу түгээж болно.

19.3 СБХ-ийг судалгааны эсвэл арилжааны бус зорилгоор түгээх тохиолдолд доорх заалтуудыг мөрдөнө.

19.3.1 МУИС-ийн хүлээсэн үүрэгт нь харшлахгүй, тухайн СБХ-ийг түгээхээс өмнө сайжруулан хөгжүүлэх шаардлагагүй, мөн түгээн дэлгэрүүлэхэд аюулгүй байдал алдагдахгүй тохиолдолд, биет хэлбэртэй судалгааны үр дүнг бусад эрдэмтэн судлаачдад судалгааны зорилгоор буюу ашгийн бус зориулалтаар нэн даруй нээлттэй болгож, түгээх бодлогыг МУИС баримтална.

19.3.2 Захиалгат буюу бусад гэрээт судалгааны ажлын үр дүнд бүтсэн СБХ-ийг хөгжүүлэх, хадгалах, түгээх, ашиглах талаарх хяналтыг судалгааны Төслийн удирдагч (PI – Principle Investigator) хариуцах ба ТДТ-тэй зөвлөлдөнө. Бусад тохиолдолд МУИС-ийн өмч хөрөнгийг мэдэгдэхүйц ашигласан хувь хэмжээг тодорхойлсноор нэгжийн удирдлага болон ТДТ хамтран хяналт тавина. Судалгааны зорилгоор гуравдагч этгээдэд шилжүүлэх эсэх ба хэзээ шилжүүлэхийг тодорхойлох нь СБХ-д хяналт тавигчийн үүрэг байна.

19.3.3 Гуравдагч этгээдээс гаралтай, Материал шилжүүлэх гэрээ ба бусад гэрээнд заасны дагуу МУИС-д хүлээлгэн өгсөн СБХ-д хяналтыг энэ журмын 19.3.2-той ижилхэн тогтооно.

19.3.4 Зах зээлд нэвтрүүлэхэд өндөр ашиг олох боломжоо хадгалахын тулд СБХ-ийг судалгааны зорилгоор солилцохыг хориглож болохгүй. СБХ нь шинжлэх ухааны болон арилжааны өндөр үнэ цэнтэй байх тохиолдолд, Төслийн удирдагч тус бүтээлийг шинжлэх ухааны зорилгоор ашиглахдаа арилжааны үнэ цэнийг нь хадгалж, зах зээлд нэвтрүүлэх явцад нь садаа учруулахгүй байх талаар ТДТ-өөс заавар зөвлөгөөг авна.

19.3.5 СБХ-ийн бүрэлдэхүүн хэсэг бүр МУИС ба бусад газарт бүтээсэн ижил төрлийн бүтээлээс ялгарах тодорхой код, нэртэй байна. Зохистой тодорхойлолтын систем боловсруулахын тулд Төслийн удирдагчаас ТДТ нь зөвлөгөө авна.

19.3.6 МУИС-ийн эзэмшлийн биологийн СБХ-ийг хүлээн авагч тал нь биологийн материалыг (СБХ-г) арилжааны зорилгоор хөгжүүлэхгүй, арилжихгүй, бусад дамжуулахгүй гэсэн нөхцөлтэй гэрээ байгуулж, үүрэг хүлээсэн цагт судалгааны зорилгоор түгээж болно. Төслийн удирдагч биологийн материалыг хэрэглэх явцдаа тусгай зааварчилгааг дагаж мөрдөхийг хүлээн авагчаас шаардах зэргээр шилжүүлсэн биологийн материалын цаашдын хэрэглээг хянаж болно.

19.3.7 Биологийн СБХ-ийг МУИС-ийн харьяалалгүй бусад этгээдэд шилжүүлэх тохиолдолд СБХ-г гарган авахад зориулсан материалын ба үйл ажиллагааны зардлыг хүлээн авагч тал хариуцах бөгөөд төлбөрийг эдгээр судалгааны зардлыг санхүүжүүлсэн данс руу шилжүүлнэ. МУИС-иас биологийн СБХ шилжүүлсэнтэй холбогдон үүссэн төлбөр тооцоог баримтжуулж, хожим аудит шалгалтаар шалгахад бэлэн болгоно.

19.3.8 Биологийн СБХ-ийг тээвэрлэх, хадгалах, хэрэглэх явцад орчны бохирдол болон бусад эрсдэл үүсэх боломжтой бол, эсвэл хүлээн авагч тал СБХ-ийг клиник туршилтад хэрэглэх бол ТДТ-д хандаж, болзошгүй аюулаас сэргийлэх, сөрөг

үр дагавар гарсан үед түүнийг арилгах тохиромжтой нөхцөлүүдийг гэрээнд тусгах талаар зөвлөгөө авна.

19.3.9 Патентаар хамгаалсан ба патент нь хэрэглээнд шилжсэн биологийн СБХ-г судалгааны багуудад түгээх үйл явцыг ТДТ хариуцна.

19.4 Биологийн СБХ-ээс бусад СБХ-ийн түгээх үйл явцыг энэхүү журмын компьютерын програм хангамжийг түгээх тухай 21 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэнэ.



20 дугаар зүйл. Компьютерийн програм хангамжаас бусад зохиогчийн эрх бүхий бүтээлийг нээлттэй түгээх

20.1 Гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээн дэх хүлээсэн үүрэгтэй зөрчилдөхгүй бол МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаач – зохиогчид харьяалагдах нэгжийн удирдлага, бүх хамтран зохиогчтойгоо тохиролцсоны үндсэнд бүтээлийг ашиглалтын төлбөргүй лицензийн гэрээгээр нээлттэй түгээх буюу шууд олон нийтийн хүртээл болгож болно. (“Технологи дамжуулах заавар”-аас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу)

20.2 Програм хангамж болон зохиогчийн эрхээр хамгаалж болохуйц бусад бүтээл нь өргөн хүрээтэй хэрэглээ бий болгох боломжтой, тухайлбал компьютерийн үйлдлийн систем зэрэг шинэ стандарт тогтоохоор байвал, зохиогч нь тухайн бүтээлээ шууд үнэ төлбөргүй олны хүртээл болгохоор хүсэлтээ ТДТ-д гаргаж болно.

20.3 Үнэ төлбөргүй олны хүртээл болгох хүсэлтийг ТДТ шийдвэрлэхдээ уг бүтээл нь хэр их дэвшил авчрах, хэрэглэхэд түвэгтэй байдал үүсгэх эсэх, олон нийт үр ашигтай хэрэглэх боломжтой эсэх, чанараа хадгалж чадах эсэх, мөн зохиогч нь үнэгүй олны хүртээл болгох замыг сонгосон шалтгаан зэргийг нягталж үзнэ.

21 дүгээр зүйл. Компьютерийн програм хангамжийг судалгааны зорилгоор болон нээлттэй эх сурвалжаар түгээх

21.1 Компьютерийн програм хангамж нь зах зээлд өндөр үнэ цэнтэй, эсвэл Төслийн удирдагч шилжүүлсний дараах хэрэглээг хянахыг хүссэн, эсвэл бүтээлийг захиалгат судалгааны ажлын хүрээнд бүтээсэн бол МУИС-ийн эзэмшлийн компьютерийн програм хангамжийг судалгааны зорилгоор бусад багт шилжүүлэх үйл явцыг ТДТ хариуцна.

21.2 ТДТ нь бүтээлийн зах зээлийн үнэ цэнийг хадгалахын тулд түгээхтэй холбогдсон гэрээ хийж, барааны тэмдэг эсвэл зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийн аль тохиромжтой хэлбэрээр хамгаалалт хийнэ.

21.3 Зохиогчид компьютерийн програм хангамжийг нээлттэй эх сурвалжаар дамжуулан түгээхийг хүсвэл ТДТ-өөс зөвлөгөө авна. ТДТ нь тухайн бүтээлд захиалагчийн өмнө зохиогчийн хүлээсэн үүрэг бий эсэх, мөн МУИС-ийн бусад оюуны өмчид сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр түгээж болох нээлттэй эх сурвалжийн талаар зөвлөгөө өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙН АРИЛЖААНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ

22 дугаар зүйл. Арилжааны үзэл баримтлал

22.1 Нийтэд үйлчлэх үүргийнхээ хүрээнд судалгааны үр шимийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн ажлыг МУИС бодлогоор дэмжинэ.

22.2 Судалгааны үр дүнг оюуны өмчийн хэлбэрээр хамгаалан түүний лицензийн эрхийг баталгаажуулж, бараа үйлчилгээг сайжруулан хөгжүүлж, нийтийн хүртээл болгоход шаардлагатай хөрөнгө оруулахад нь үйлдвэрлэгчийг урамшуулан дэмжих бодлого баримтлана.

23 дугаар зүйл. Зах зээлд нэвтрүүлэх - Арилжаалах

23.1 Технологид лиценз олгох ажлыг ТДТ хариуцна. Тухайн технологийн зах зээлийг судлах, худалдан авагч этгээдийг тодорхойлох, лиценз худалдан авагчтай гэрээний талаар зөвшилцөх, зохих лиценз болон бусад гэрээний талаар хэлцэл хийх, гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, бүтээгч буюу зохиогч нарт энэ журмын дагуу роялти (шимтгэлийн орлого) ашгийг хуваарилах зэрэг нь ТДТ-ийн үндсэн үйл ажиллагаа байна.

23.2 Тохиромжтой нөхцөлд ТДТ нь роялти ашгийн тодорхой хувьтай тэнцүү хэмжээгээр компанийн хөрөнгөөс (equity) хувь эзэмшиж болно.

23.3 Технологийн арилжааг хөгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

23.3.1 Лиценз олголтыг амжилттай хэрэгжүүлэхэд бүтээгч буюу зохиогч нар дэмжин тусалж, хамтран ажиллана.

23.3.2 МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаач нь өөрийн эзэмшдэг технологийг МУИС-иар дамжуулах хөгжүүлэхийг хүсвэл Технологи задлах маягыг бөглөж, ТДТ-д өгснөөр эзэмших эрхээ МУИС-д шилжүүлэн өгч болно. ТДТ тухайн технологийг эзэмших эрхийг шилжүүлэн авах эсэхийг шийдвэрлэхдээ зах зээлийн үнэ цэн ба зах зээлд нэвтрүүлэх боломж зэргийг үнэлж, роялти хуваарилалтын журмын дагуу лиценз олгох боломжийг тодорхойлно. Шаардлагатай бол Оюуны өмчийн үнэлгээний хэсгийн зөвлөмжийг авна.

23.3.3 Судлаач, суралцагч, зочин судлаачид өөрсдийн хувьдаа эзэмшдэг технологийг арилжаалах арга замыг сонгоход ижил тэгш эрхтэй оролцоно. Тухайн технологи ямар нэг байдлаар МУИС-ийн захиалгат болон гэрээт судалгааны хэсэг, эсвэл гэрээгээр хүлээсэн үүрэгт ажлынх нь үр дүн, эсвэл МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц ашигласан зэрэгт хамааралгүй эсэхийг магадлан шалгана.

23.3.4 Энэ журмын 23.3.3-д дурдсан нөхцөлийн аль нэг нь илэрсэн тохиолдолд бүтээгч буюу зохиогч нар ТДТ-өөс тохирох лиценз олгохыг, эсвэл 4-р бүлэгт заасанчлан МУИС-ийг эзэмших эрхээсээ татгалзахыг хүсч болно. Эрхээс татгалзахыг хянах хүсэлтээ тусгай маягтын (А1 маягт) дагуу бөглөн ТДТ-д өгнө.

23.3.5 Технологийн хөгжилд эерэг үр дүн гарсан ч ирээдүйн шинэ бүтээлтэй холбоотой ямар нэг амлалт, баталгааг МУИС-иас лиценз худалдан авагч этгээдэд гаргахгүй. Онцгой нөхцөлд маш нарийн тодорхойлсон тусгай заалтуудыг гэрээнд тусгаснаар дагавар (subordinate patents) патент болон лицензтэй програм хангамжийн хувилбар бүтээгдэхүүн зэрэгт ирээдүйн шинэ бүтээлийн баталгаа гаргаж болно.

23.3.6 ТДТ лицензийн зохицуулалтын талаар зөвлөх үйлчилгээний гэрээ хэлцэлийг бүтээгч буюу зохиогч хувь хүнтэй хийхгүй.

24 дүгээр зүйл. Патентыг арилжаалах

24.1 Технологи задлах маягыг ТДТ-д хүлээн авсны дараа тухайн шинэ бүтээлийг патентжуулах болон зах зээлд үр ашигтай нэвтрүүлэх боломжтой эсэх, мөн захиалагчдын өмнө гэрээгээр ямар үүрэг хүлээсэн зэрэгт технологид лиценз олголт хариуцсан ажилтан үнэлгээ хийнэ.

24.2 ТДТ тухайн технологитой холбоотой шүүлт, зах зээлийн судалгааны ажилд бүтээгч буюу зохиогчдоос нэг хүнийг оролцуулах хүсэлт гаргаж болно.

24.3 Хэрэв шинэ бүтээл ямар нэг захиалгат төслийн үр дүн байвал ТДТ нь мэдүүлэг бүрдүүлэн патентын эрхийг бүртгүүлэхээр өгөхийн сацуу тохирох лицензийн гэрээ хэлцэлийг тус захиалгат судалгааны гэрээнд нийцүүлэн эхлүүлнэ.

24.4 ТДТ нь судалгааны гэрээ бүрт патентын онцгой нөхцөлийн талаар зөвлөгөө өгч болно.

25 дугаар зүйл. Зохиогчийн эрхтэй бүтээлийг арилжаалах

25.1 Энэ журамд заасан онцгой нөхцөлүүдээс бусад тохиолдолд, МУИС-ийн эзэмшлийн зохиогчийн эрхээр хамгаалах боломжтой ажилд лиценз олгохыг ТДТ хариуцна.

25.2 МУИС эзэмших эрхийг нь эдэлдэггүй зохиогчийн эрхээр хамгаалах боломжтой ажлыг зохиогч нь эрхээ шилжүүлэхийг зөвшөөрч, Технологи Задлах Маягтыг бөглөж өгснөөр лиценз олгох ажлыг ТДТ хариуцаж болно.

25.3 Компьютерийн програм хангамжийг зах зээлд нэвтэрүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

25.3.1 МУИС эрхийг нь эзэмших компьютерийн програм хангамжид патентын эсвэл зохиогчийн эрхийн хамгаалалт хийж болно.

25.3.2 Програм хангамж ТДТ-өөр дамжин патент болон зохиогчийн эрхийн лицензийн олон хэлбэрээр зах зээлд нэвтрэх боломжтой байх ёстой.

25.3.3 Зохиогч болон түүний харьяалагдах нэгж нь энэхүү журамд тодорхойлсон роялти ашгаас ижил тэнцүү хувь хүртэнэ. Бичгээр гэрээ байгуулан роялти ашгаас хүртэх хувиа тохиролцож болно.

25.3.4 Бүтээсэн програм хангамж нь ТДТ-өөр дамжиж лицензийн гэрээгээр гуравдагч этгээдэд очсон байх тохиолдолд зохиогч нь судалгааны зорилгоор үнэгүй лиценз олгох хүсэлтэй бол заавал ТДТ-тэй хамтарч энэ ажлыг зохион байгуулна.

25.4 Энэ журамд МУИС-ийн үйл ажиллагаанд зориулсан буюу МУИС-ийн нэгжийн хэрэгцээнд зориулан захиалгаар бүтээсэн аливаа дүрс бичлэгийн бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалж, түүнийг эзэмших болон арилжаалах эрхийг тухайн тохиолдол бүрт хийсэн гэрээний дагуу шийднэ.

26 дугаар зүйл. Барааны тэмдэг, маск загварыг арилжаалах

26.1 МУИС-ийн эзэмшдэг бараа болон үйлчилгээний тэмдэгт лиценз олгохыг ТДТ хариуцна.

27 дугаар зүйл. Маск загварыг арилжаалах

27.1 МУИС-ийн эзэмшдэг маск загваруудад лиценз олголтыг ТДТ хариуцна. Маск загварын роялти ашгийн хувийг энэ журмын 30 дугаар зүйлд заасны дагуу олгоно.

28 дугаар зүйл. Судалгааны биет хөрөнгийг арилжаалах


28.1 МУИС нь өөрийн эзэмшдэг Судалгааны биет хөрөнгө (СБХ)-ийг зөвхөн ТДТ-өөр дамжуулан зах зээлд нэвтрүүлэх бодлого баримтлана.

28.2 Хэрэв МУИС-ийн хөгжүүлсэн СБХ-ийг арилжааны зориулалтаар бүтээсэн бол түгээхдээ лицензийн гэрээнд дараах нөхцлийг тусгана. Үүнд:

28.2.1 СБХ-г хэрхэн ашиглах талаар ТДТ-тэй урьдчилан тохиролцсон нөхцөл, заалтуудыг заавал багтаасан байх;

28.2.2 Ашиглах СБХ-д, эсвэл тухайн СБХ-өөс үүссэн дагавар бүтээгдэхүүнд хүлээх МУИС-ийн хариуцлагын хэмжээг тодорхойлсон байх;

28.2.3 Бусад биет өмчийн хэрэглээтэй холбоотой ямар нэг биет бус өмчийн (патент зэрэг) эрхийн тухай заалтыг багтаасан байх.



29 дүгээр зүйл. МУИС бүтээгч буюу зохиогчид нь лиценз олгох

29.1 МУИС-ийн судлаач, суралцагч, зочин судлаач - бүтээгч буюу зохиогчид нь өөрсдийн бүтээсэн МУИС-ийн эзэмшдэг шинэ бүтээлд, эсвэл зохиогчийн эрхтэй материалд арилжааны зорилгоор лиценз авах хүсэлт гаргаж болно.

29.2 Бүтээгч буюу зохиогч нь ямар нэг давуу эрх эдлэхгүй ба МУИС-ийн гуравдагч этгээдтэй харилцдаг журмын дагуу ашиг сонирхолын зөрчилдөөн үүсгэлгүй ижил тэгш эрх эдэлнэ.

29.3 Бүтээгч буюу зохиогчтой лицензийн гэрээг байгуулахдаа тухайн технологийг хөгжүүлж түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө болон оногдох роялти төлбөрийн талаар тусгана. Ашиг сонирхолын зөрчлөөс сэргийлэх үүднээс гэрээний хэлцэл, тохиролцоонд энэ журмын 32 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлана.

29.4 Олон зохиогчтой, хөгжүүлэхэд урт хугацаа зарцуулсан, зохиогчийн эрх бүхий чухал төслүүдийн материалыг хамгийн үр бүтээлтэйгээр түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг ТДТ-тай зөвлөж, тусгай хэлцэл хийх шаардлагатай.

29.5 Энэ журамд заасны дагуу бүтээгч буюу зохиогчийн гаргасан хүсэлтэд МУИС нь 90 хоногт багтааж хариу өгнө. Зохих үнэлгээ хийх боломжгүй, бүрэн боловсроогүй програм хангамж зэрэг ажлын тухайд хариу өгөхөөс өмнө МУИС нэмэлт боловсруулалт хийхийг шаардах эрхтэй.

30 дугаар зүйл. Роялти ашиг хуваарилах

30.1 МУИС хүлээн авсан нийт роялти ашгийг улирал тутамд болон санхүүгийн жилийн эцсээр энэ журмын 30.3-д заасны дагуу хуваарилна.

30.2 Роялти ашгаас хувь авсан бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, дундын лабораториуд, мөн МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн сангаас санхүүжилт авсан этгээд энэ журмын дагуу тухайн хүлээн авсан хөрөнгийг зөвхөн сургалт судалгааг дэмжих зориулалтаар зарцуулна.

30.3 Дараах томъёоллын дагуу роялти орлогыг хуваарилна. Үүнд:

30.3.1 Бүтээгч буюу зохиогчийн хувийг бодохдоо Бүрдэл (case) тус бүрт гарч ирэх зохиогчийн роялти ашгийг хуваарилахдаа дараах аргачлалаар тооцно.

30.3.1.1 Нийт Роялти орлогоос шууд зардлыг хасна. Зарим тохиолдолд Нөөц бүрдүүлснээр Үлдэгдэл роялти ашиг бий болно.

30.3.1.2 Үлдэгдэл роялти ашгийн гуравны нэг буюу бүтээгчийн хувийг бүтээгч, зохиогч нарт олгоно.

30.3.1.3 Бүтээгчийн хувийг олгох хуваарилалт нь бүтээгч буюу зохиогчдын захиалгат судалгааны гэрээнд зөвшөөрсөн нөхцөлтэй ижил байх ёстой. Бүтээгчийн хувийг хүн бүрт харилцан адилгүй хуваарилахыг зөвшөөрч бүх бүтээгч буюу зохиогчид гарын үсэг зуран бичгээр ирүүлээгүй тохиолдолд Үлдэгдэл роялти ашгаас олгох бүтээгчийн хувийг бүтээгч нарт ижил тэнцүү хувааж хуваарилна.

30.3.2 МУИС ба МУИС-ийн нэгжийн Роялти хувь бодохдоо дараах аргачлалаар тооцно.

30.3.2.1 Үлдэгдэл роялти ашгийн гуравны нэгийг МУИС, бүтээгч буюу зохиогчийн харьяалагдах МУИС-ийн нэгжид хуваарилна.

30.3.2.2 Хуваарилалт нь оролцсон бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, дундын лабораториудын захиалгат судалгааны гэрээнд зөвшөөрсөн нөхцөлтэй ижил байх ёстой. Сургууль, хүрээлэн, төв, дундын лабораториуд тус бүрт харилцан адилгүй хуваарилахыг зөвшөөрч бүх нэгжийн хариуцлагатан (захирал, дарга) нар гарын үсэг зуран бичгээр ирүүлээгүй тохиолдолд Үлдэгдэл роялти ашгаас олгох хувийг ижил тэнцүү хувааж хуваарилна.

30.3.3 ТДТ-д Роялти хувь бодохдоо дараах аргачлалаар тооцно.

30.3.3.1 Үлдэгдэл роялти ашгийн гуравны нэгийг МУИС-ийн ТДТ-д хуваарилна.

30.3.3.2 ТДТ-д хуваарилсан роялти ашгийн гуравны нэгийг нь тус технологи дамжуулалтанд оролцсон этгээдийг урамшуулах, гуравны нэгийг нь технологи дамжуулалтыг дэмжих үйл ажиллагаанд, үлдсэн хувийг Нөөцөд төвлөрүүлнэ.

30.4 Хэрэв хэн нэг бүтээгч буюу зохиогч нь захиалгат судалгааны ажлын гэрээг зөрчиж МУИС-ийн нэр хүнд, өмч хөрөнгө, эд материалд хохирол учруулсан нь илэрч, шалгалтаар нотлогдвол тус бүтээгч буюу зохиогчид тухайн захиалгат судалгааны гэрээний үр дүнд бий болсон шинэ бүтээлийн роялти ашгийн хэсгийг нь эсвэл бүгдийг нь олгохоос МУИС-ийн Ёс зүйн хороо, Оюуны өмчийн хорооны санал дүгнэлтэнд үндэслэн Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал татгалзаж болно.

30.5 МУИС-иас албан ёсоор хүлээн зөвшөөрдөг хүрээлэн буюу төв болон дундын лаборатори роялти орлого авах эрхтэй.

31 дүгээр зүйл. Роялти – онцгой тохиолдолд хуваарилах

31.1 Технологийг МУИС-ийн нэгж бие даан хэрэгжүүлсэн төслийн үр дүнд, эсвэл бүтээгч буюу зохиогчийг хялбар тодорхойлох боломжгүй нөхцөлд бүтээсэн тохиолдолд хувь хүнд ногдох роялти ашгийн хуваарилалт түгээмэл бус байх онцгой тохиолдол гарч болно. Энэ тохиолдолд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

31.1.1 ТДТ-ийн захирал онцгой тохиолдол бий болсон нөхцөл байдлыг төслийн ерөнхий удирдагч (захиалгат судалгааны ажил биш тохиолдолд нэгжийн удирдлага)-тай зөвлөсний үндсэнд тогтооно.

31.1.2 Роялти ашиг нь хувь хүнд оногдохооргүй байх тохиолдолд хуваарилалтыг МУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал баталсны дагуу хуваарилна.

31.2 МУИС нь оюуны өмчөө ашиглуулсан роялти орлогын оронд эсвэл роялти орлогын тодорхой хэсгийн оронд компаниас хувь эзэмшиж болно.

31.3 Бүтээгч буюу зохиогч нь компаниас хувь эзэмшихээр болсон тохиолдолд МУИС-д ногдох хувиас хуваалцахгүй.

32 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх тухай

32.1 МУИС өөрийн эзэмшдэг технологио эзэмших эрхээсээ татгалзаж бүтээгч буюу зохиогчид нь шилжүүлэх, эсвэл лиценз олгохоос өмнө дараах шинжийн аль нэг нь ажиглагдвал ашиг сонирхлын зөрчилдөөн үүссэн гэж үзнэ. Үүнд:

32.1.1 МУИС-аас оюутнуудад сургалт явуулах үүрэг хариуцлагад сөргөөр нөлөөлөх;

32.1.2 Бүтээгч буюу зохиогчийн МУИС дахь ажил үүргээс цаг хугацаа, ажлын чиг үүргийн хувьд хэтэрсэн байх, зохисгүй нөлөө гарах;

32.1.3 Олон нийтийн хэрэгцээг хангах МУИС-ийн үүрэгт сөрөг нөлөө гарах;

32.1.4 Монгол Улсын хууль тогтоомж болон МУИС-ийн дүрэм, журмуудад заасан ашиг сонирхлын зөрчилдөөн үүсэх.

32.2 МУИС-иас гарах гарааны компанийн хувьд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхийн тулд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

32.2.1 Хэрэв бүтээгч буюу зохиогч нь шинэ бүтээлийн лиценз эзэмшигч компани, аж ахуйн нэгж (ААН)-ийн үнэт цаас, эсвэл хувь, эсвэл үүсгэн байгуулагчийн хувьцаа ба/эсвэл опцион (option) эзэмшдэг, эсвэл удахгүй эзэмших гэж байгаа бол Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал шийдвэр гаргаснаар МУИС нь роялти орлогын оронд хувь эзэмшиж болно.

32.2.2 Хэрвээ бүтээгч буюу зохиогч нь компани үүсгэн байгуулагдсаны дараа тус компаниас хувь эзэмшихийн зэрэгцээ МУИС-д ажилласан хэвээр үлдэх бол тухайн бүтээгч буюу зохиогч Зөрчилдөөнөөс зайлсхийх баримтанд гарын үсэг зурсан байх шаардлагатай (А4 маягт).

32.2.3 МУИС нь эсвэл МУИС-ийн бүтээгч буюу зохиогч нь хувь эзэмших сонирхолтой (хувьцаа, option, warrant зэрэг хувь эзэмшихтэй дүйх санхүүгийн бусад хэрэгслийг багтаан) үед дараах тохиолдлоос бусад тохиолдолд ирээдүйн лиценз эзэмшигч талаас судалгааны санхүүжилтийг МУИС авахгүй. Үүнд:

32.2.3.1 Судалгааны ажил нь лиценз олгосон патентэд илэрхийлсэн шинэ бүтээлийн үр дүнтэй холбоогүй, програм хангамжийн хувьд лиценз олгосон програм хангамжийн хувилбар ажил биш тохиолдолд;

32.2.3.2 Судалгааны ажлыг бүтээгч буюу зохиогчийн лабораторийн багаас өөр баг гүйцэтгэх бол;

32.2.3.3 Лиценз эзэмшигчийн санхүүжүүлэх судалгааны төсөлд бүтээгч буюу зохиогчийн оюутан оролцоогүй тохиолдолд.

32.3 Хэрвээ бүтээгч буюу зохиогч жижиг компаниас судалгааны төсөв авахын тулд хувь эзэмшихээс татгалзвал, МУИС лицензийн гэрээгээр хувь эзэмшихээс татгалзана. Энэ тохиолдолд бүтээгч буюу зохиогч дараа нь хувь эзэмших талаар ямар нэгэн алхам хийхгүй байх, судалгааны гэрээ дууссанаас хойш 2-оос доошгүй жилийн дотор хувь эзэмших талаар гэрээ хэлцэл хийхгүй байх зэргийг гэрээндээ тусгасан байх ёстой.

32.4 Лиценз олгох албаны ажилтан ашиг сонирхолын аливаа зөрчилдөөн гарахаас сэргийлэхийн тулд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

32.4.1 ТДТ-ийн ажилтан бүр МУИС-ийн оюуны өмчийг ашиглах лицензтэй, хувьцаа гаргаагүй компанид ямар нэг байдлаар хувийн хөрөнгө оруулалт хийхгүй байх;

32.4.2 Хэрвээ ажилтан вэнч хөрөнгө оруулалтын хамтрагч бол, тэр ажилтан тухайн вэнч сангаас хөрөнгө оруулалсан ямар ч компаниас МУИС-ийн оюуны өмчид лиценз авах гэрээ хэлцэлд оролцохыг хориглох ба саналын эрхтэй хамтрагчид МУИС-ийн компанийг тухайн вэнч сан руу санал болгохыг хориглоно.

32.4.3 Компани, ААН нь МУИС-ийн оюуны өмчид лиценз эзэмших гэж буй талаарх мэдээлэл, мэдлэг нь ямар нэг байдлаар гадагш алдагдаж, тухайн оролцогч компани, ААН-ийн хувь, хувьцааны үнэд нөлөөлж болохуйц байдал гаргахгүй байх талаар ТДТ-ийн ажилтан тусгай үүргийг хүлээнэ.

32.4.4 Олж авсан мэдээллээ өөрийн гэр бүл, найз нөхөд, бизнесийн түнш нарт давуу байдал олгож хөрөнгө оруулалт хийх зорилгод ашиглахыг хатуу хориглоно.

33 дугаар зүйл. Оюуны өмчийн хороо

33.1 МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Оюуны өмчийн хороо нь ТДТ-ийн үйл ажиллагааг ерөнхийд нь хянана.

33.2 Оюуны өмчийн хороо нь ТДТ-ийн үйлчилгээ үзүүлдэг голлох технологийн салбар тус бүрээс төлөөлөл багтаасан байна.

33.3 Оюуны өмчийн хорооноос технологи дамжуулалт, шинэ технологийн талаарх бодлого, зөвлөмж гаргуулахаар тусгай шинжээчдээс бүрдсэн үнэлгээний ажлын хэсгийг шаардлагатай тохиолдолд зохион байгуулж ажиллуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ. СУДЛААЧ, СУРАЛЦАГЧ БА ЗОЧИН СУДЛААЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

34 дүгээр зүйл. Үүрэг хариуцлагын тухай

34.1 МУИС-ийн бодлогоор энэхүү журамд заасан технологийг эзэмших зарчмыг МУИС-д ажил эрхэлж буй, эсвэл захиалгат судалгааны төсөлд оролцож буй, эсвэл МУИС-ийн санхүүжилт ба өмч хөрөнгийг ашиглаж буй бүх этгээд хүлээн зөвшөөрч бүх оролцогч энэ журмын 35 дугаар зүйл дэх гэрээний заалтуудыг зөвшөөрч Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээнд гарын үсэг зурна.

35 дугаар зүйл. Хувь хүний шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээ

35.1 Энэхүү нууцлалын гэрээнд доор дурдсан этгээдүүд дараах нөхцөлд гарын үсэг зурна. Үүнд:

35.1.1 Захиалгат судалгаа эсвэл МУИС-ийн санхүүжүүлсэн төслөөс санхүүгийн дэмжлэг авсан этгээд Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээ(А5 маягт)-нд гарын үсэг зурах ёстой.

35.1.2 Захиалгат судалгаа эсвэл МУИС-аас санхүүжүүлсэн судалгааны үр дүнд шинэ бүтээлийг бүтээсэн буюу хөгжүүлсэн, бодит хэрэглээнд нэвтрүүлсэн, эсвэл технологийг хөгжүүлсэн этгээд;

35.1.3 Цалин буюу бусад хэлбэрийн дэмжлэгийг авсан эсэхээс үл хамааран МУИС-ийн санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласан этгээд;

35.1.4 МУИС-ийн бүх зочин судлаач болон бусад гадаад мэргэжилтэн (А6 маягт).

35.2 МУИС-ийн нэгж бүр захиалгат төсөлд оролцсон, эсвэл оролцох магадлалтай, эсвэл тухайн нэгжээр дамжуулан МУИС-ийн мэдэгдэхүйц өмч хөрөнгө, санхүүжилтыг авч ашиглах боломжтой судлаач, суралцагч, зочин судлаач бүрийг Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээнд гарын үсэг зуруулах үүрэгтэй.

35.3 Шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээг гурван хувь үйлдэж гарын үсэг зуран хувь хүн, МУИС-ийн нэгж, ТДТ тус бүр нэг хувийг хадгална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

36 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал

36.1 МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал нь энэхүү журамтай холбоотой ямар нэгэн маргаантай асуудлыг шийдвэрлэнэ.

36.2 Зарим онцгой нөхцөл байдалд Эрдэм шинжилгээ инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал энэ журмаар зохицуулагдаагүй шийдвэрийг МУИС-ийн Оюуны өмчийн хороотой зөвшилцсөний үндсэн дээр гаргаж болно.

37 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс

37.1 Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс (ЭШИХ) нь МУИС ба захиалагч, гэрээлэгч байгууллага хоорондын захиалгат судалгааны гэрээг байгуулах үйл явцыг удирдах бөгөөд захиалагчийн санхүүжүүлсэн судалгааны дүнд бүтсэн буюу хөгжсөн технологийг тухайн захиалагч лицензээр эзэмших давуу эрхийг нь баталгаажуулж өгнө.

37.2 Судалгааны ажил нь технологи хөгжүүлэхээс чухал, давуу зэрэгтэй байна. Аливаа технологийг нийтийн хүртээл болгох явцдаа МУИС-ийн судалгаанд ямар нэг хэлбэрээр саад тотгор болохуйц баталгаа гаргасан зүйл заалтыг гэрээний нөхцөлд оруулахыг хатуу хориглоно.

37.3 Ойлгомжгүй нөхцөл байдал үүссэн эсхүл давуу зэргийн хувьд зөрчилдөөн гарсан тохиолдолд Эрдэм шинжилгээ инновацийн асуудал эрхэлсэн дэд захиралд уламжилж шийдвэрлүүлнэ.

38 дугаар зүйл. Технологи дамжуулах төв (ТДТ)

38.1 МУИС-ийн ТДТ нь дараах үндсэн хоёр зорилготой. Үүнд:

38.1.1 Нэгдүгээрт: МУИС-д хөгжүүлсэн технологийг нийтийн тусын тул ашиглуулахаар дамжуулахад үйлчлэх;

38.1.2 Хоёрдугаарт: 38.1.1-д заасан нэгдүгээр зорилгод нийцүүлэн сургалт болон судалгааг дэмжихэд зориулан хуулиар хориглоогүй нэмэлт хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээр МУИС-ийг хангах.

38.2 МУИС-ийн технологи хөгжүүлэгч эсвэл аж үйлдвэрлэгчтэй хамтран ажиллах явцдаа хэвлэн нийтлэх, хурал зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэргээр шинжлэх ухаан, техникийн мэдээллийг түгээх МУИС-ийн үндсэн ажилд ТДТ нь саад тотгор үзүүлэхгүй ажиллах зарчмыг баримтлана.